



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ

2013 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

"Ногоон булан" орон нутгийн өмчит үйлдвэрийн
газрын дүрмийг шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрин нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 "ж", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дүүргийн "Ногоон булан" ахмадын амралт, сувилал орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын удирдлагыг томилж, бүтэц орон тоог батлан үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллан, үр дүнг жил бүр тайлагнан ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Хурлын ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 68 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ